



**“Оюу толгой” ХХК**

Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчин

Биологийн олон янз байдлын мониторинг, үнэлгээний төлөвлөгөө  
(БОЯБМҮТ)

<b>Биологийн олон янз байдлын мониторинг, үнэлгээний төлөвлөгөө</b>		
Хүчинтэй болох: 2015.12.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е14-PLN-0006-М	Хувилбар: 1.0

**Гарчиг**

1. <b>ТАНИЛЦУУЛГА</b> .....	3
2. <b>ЗОРИЛГО</b> .....	3
3. <b>АЖИЛ ҮҮРГИЙН ХУВААРЬ, ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА</b> .....	4
3.1 Үндсэн ажлын хэсгүүд.....	4
4. <b>БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН ДҮРЭМ ЖУРАМ БОЛОН ЭЕРЭГ АХИУ НӨЛӨӨ ҮЗҮҮЛЭХ ЗОРИЛГО</b> .....	5
4.1 Бусад удирдлагын төлөвлөгөөтэй уялдах нь.....	6
5. <b>2015 ОНООС ӨМНӨ ХИЙГДСЭН БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН МОНИТОРИНГ</b> 8	
6. <b>МОНИТОРИНГИЙН ХАМРАХ ХҮРЭЭ</b> .....	8
6.1 Мониторингийн хугацаа.....	8
6.2 Мониторингийн хамрах хүрээ - Газар зүйн.....	9
6.3 Мониторингийн хамрах хүрээ – Үзүүлэлтийн төрлүүд.....	9
6.4 Мониторингийн хамрах хүрээ – Амьдрах орчин, төрөл зүйлс.....	10
7. <b>БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ХАМГААЛАХАД ЗОРИУЛСАН ХӨРВӨХ МЕНЕЖМЕНТИЙН АРГА</b> зүй.....	10
8. <b>МОНИТОРИНГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ</b> .....	11
9. <b>МОНИТОРИНГИЙН ЗОРИЛТ, БОСГО ҮЗҮҮЛЭЛТҮҮД</b> .....	23
9.1 ЭАН үзүүлэх үйл ажиллагааны зорилтууд.....	23
9.2 Хөрвөх менежментийн босго үзүүлэлтүүд.....	23
9.3 Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө, нөлөөлөл бууруулах үйл ажиллагаа.....	26
9.4 ЭАН үзүүлэх үйл ажиллагааны төлөвлөлт, урьдчилсан тооцоог шинэчлэх.....	26
10. <b>БАРИМТ БИЧГИЙН ХЯНАЛТ</b> .....	27

**Зураг 1.** Биологийн олон янз байдлын мониторингтой холбоотой баримт бичгийн хоорондын уялдаа холбоо..... 7

**Зураг 2:** Мониторингийн талбайн жишээ – туруутан амьтдын газрын ажиглалт судалгааны талбай..... 9

**Зураг 3.** Хөрвөх менежментэд хамаарах үйл ажиллагаа, баримт бичгүүдийн уялдаа холбоо..... 10

**Зураг 4:** ЭАН үзүүлэх үйл ажиллагааны босго үзүүлэлт, хариу арга хэмжээ, үр дагаврын схем..... 24

**Хүснэгт 1.** Мониторингийн бүрэлдэхүүн хэсгүүдэд хийх хяналтын үнэлгээний төрлүүд болон давтамж..... 11

**Хүснэгт 2.** Эн тэргүүнд хамгаалах шаардлагатай биологийн олон янз байдлын үзүүлэлтийн тойм (дэлгэрэнгүйг Хавсралтаар харуулав). ..... 12

<b>Биологийн олон янз байдлын мониторинг, үнэлгээний төлөвлөгөө</b>		
Хүчинтэй болох: 2015.12.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е14-ПЛН-0006-М	Хувилбар: 1.0

## 1. ТАНИЛЦУУЛГА

Энэхүү Биологийн олон янз байдлын мониторинг, үнэлгээний төлөвлөгөө (БОЯБМҮТ) нь БОННУ-нд заасан эн тэргүүнд хамгаалах шаардлагатай амьтан, ургамлын төрөл зүйлс, амьдрах орчны мониторингийн ажлын хамрах хүрээ, аргачлал, хариу арга хэмжээг тодорхойлох зорилготой. Энэхүү баримт бичгийг дараах зүйлсэд үндэслэн тогтмол хянаж, шинэчилж байна.

- Мониторингийн ажлын дүн, нэмэлт мэдээлэл, мэдлэг;
- Дүйцүүлэн хамгааллын менежментийн төлөвлөгөө (ДХМТ)-ний хүрээнд авч хэрэгжүүлэх ажлууд, зорилтот үр дүнг шинэчлэх;
- Биологийн олон янз байдлын бүрдэл хэсгүүдэд үүсэх байгалийн жам ёсны өөрчлөлтийн мэдээ, мэдээллийг хуримтлуулах (ингэснээр одоо байгаа эсхүл шинээр үүсгэх хөрвөх менежментийн босго үзүүлэлтүүдэд өөрчлөлт орж болно)

Ажлын Стандарт Журам нь байгууллагийн арга зүйг архивлах мөн шинэ ажилчдад харьцуулсан болон урт хугацааны тогтвортой мониторингийн судалгааны арга зүйг дахин боловсруулах боломж олгох зорилготой юм.

## 2. ЗОРИЛГО

БОЯБМҮТ нь дараах зорилготой:

- Хөрвөх менежментийг боловсруулахын тулд үйл ажиллагааны явцад гарах нөлөөлөл (эерэг, сөрөг), мөн нөлөөллийг бууруулах (нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах) ажлуудын үр дүнд үнэлгээ өгөх
- Төсөл нь эн тэргүүнд хамгаалах шаардлагатай биологийн олон янз байдалд урт хугацаандаа Эерэг ахиу нөлөө (ЭАН) үзүүлж байгааг хянаж байгааг батлан харуулах
- Менежментийн туршилтын хувилбаруудыг шинжлэх ухааны үүднээс үнэлэх.

Мониторингийн явцад дараах зүйлсийг хэмжинэ:

- Оюу толгойн (ОТ) үйл ажиллагаанаас үүдэн биологийн олон янз байдалд учирсан сөрөг нөлөө
- Нөлөөлөл бууруулах үйл ажиллагааны үр дүн
- Урт хугацааны туршид дүйцүүлэн хамгаалах үйл ажиллагаанаас үүдэн гарсан эерэг нөлөө.

Бодит эерэг нөлөөллийг бодит сөрөг нөлөөтэй харьцуулж эн тэргүүнд хамгаалах шаардлагатай ажлын үр дүнг тодорхойлох буюу ЭАН үзүүлэх зорилтын биелэлтийн явц болон ЭАН үзүүлэх урьдчилсан тооцоог хянах, дахин шинэчлэх.

Эн тэргүүнд хамгаалах шаардлагатай биологийн олон янз байдлын бүрэлдэхүүн хэсэг болгонд ЭАН үзүүлэх үйл ажиллагааны зорилт нь тухайн бүрэлдэхүүн хэсэг болгонд тохируулсон томъёогоор илэрхийлэгдэх бөгөөд “эерэг нөлөө > сөрөг нөлөө” байх ёстой. (ЭАН үзүүлэх ажиллагааны урьдчилсан тооцоонд дэлгэрэнгүй заасны дагуу). Эерэг нөлөө, сөрөг нөлөөтэй холбоотой бүх арга хэмжээг энэхүү БОЯБМҮТ-нд тусгасан.

Энэхүү баримт бичиг нь биологийн олон янз байдлын мониторингийн бүхий л хэлбэрийг

<b>Биологийн олон янз байдлын мониторинг, үнэлгээний төлөвлөгөө</b>		
Хүчинтэй болох: 2015.12.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е14-PLN-0006-М	Хувилбар: 1.0

багтаасан нэгдсэн хөтөлбөр болж байгаа юм. Энэ нь “төлөв байдал-дарамт-хариу арга хэмжээ” гэсэн загварт суурилсан болно.

### 3. АЖИЛ ҮҮРГИЙН ХУВААРЬ, ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

ОТ-н Биологийн олон янз байдлын баг (амьтан, ургамал, нөхөн сэргээлтийн мэргэжилтэн) нь БОЯБМҮТ-ний хэрэгжилтийг хариуцах, тэр дундаа БОЯБМҮТ-нд заасан шаардлагуудыг цаг хугацаанд нь багтаан биелүүлэх техникийн үр чадвар бүхий биологийн олон янз байдлын судалгааны болон байгаль хамгаалах байгууллагуудтай хамтран гэрээ, ажлын төлөвлөгөө боловсруулах, удирдан зохицуулах үүрэгтэй. Жилийн ажлын тайланд дараах зүйлсийг тусгана.:

- Мониторингийн хээрийн ажлын нарийвчилсан хуваарь;
- Төслийн ажиллах хүчин;
- Ажилчдын ажил үүргийн хуваарь, үүрэг хариуцлага;
- Тоног төхөөрөмж худалдан авалт, засвар үйлчилгээ;
- Дүн шинжилгээ, техникийн төлөвлөлт;
- Тайлагналын хуваарь;
- Сургалт болон чадавхи бэхжүүлэх төлөвлөгөө.

ОТ-н Биологийн олон янз байдлын багийн ерөнхий төлөвлөлт (биологийн олон янз байдлын холбогдох бүх үзүүлэлтэд хяналт тавих үүднээс) болон өдөр тутмын төлөвлөлтийг удирдан чиглүүлэхэд БОЯБМҮТ-г ашиглана. БОЯБМҮТ-ний хүрээнд Экосистемийн үйлчилгээний мониторингд ашиглах хэд хэдэн үзүүлэлтийг цуглуулна. Экосистемийн үйлчилгээний мониторингийн төлөвлөгөөнд тусгасны дагуу Экосистемийн үйлчилгээний мониторинг (дүн шинжилгээ, үнэлгээ, тайлагнал) хариуцах Нийгмийн хариуцлагын баг нэмэлт үзүүлэлтүүдийг цуглуулна.

ОТ-н Амьтан судлалын мэргэжилтэн БОЯБМҮТ-ний хэрэгжилтийг ерөнхийд нь хариуцах бөгөөд босго үзүүлэлт хэтэрсэн эсвэл эсрэг хандлага илэрсэн үед менежментийн хариу арга хэмжээг зохион байгуулах үүрэгтэй. Зарим төрлийн менежментийн хариу арга хэмжээг авахад ОТ-н бусад хэлтсүүдтэй хамтран ажиллах шаардлагатай байж болох ч Амьтан судлалын мэргэжилтэн нь хариу арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг нийтэд нь зохион байгуулах үүрэгтэй болно.

#### 3.1 Үндсэн ажлын хэсгүүд

Энэхүү төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дараах дотоод үндсэн ажлын хэсгүүд оролцоно (өөрөөр хэлбэл энэхүү БОЯБМҮТ-ийн бүрэлдэхүүн хэсгүүдийг хэрэгжүүлэх үүрэгтэй этгээдүүд):

- Усны баг (усны мониторингийн үр дүн);
- Байгаль орчны баг (агаарын чанар, тоосжилтын мониторингийн үр дүн);
- Нийгмийн хариуцлагын баг (орон нутагтай холбоотой мониторингийн үр дүн);
- Аюулгүй байдлын баг (хууль бусаар ургамал түүх, ан амьтан агнахад тавьсан мониторингийн үр дүн);
- Тээврийн баг (уурхайн цогцолбороос гадуурх тээвэр, тээврийн хэрэгслийн мониторингийн үр дүн);
- Сургалтын баг (үндсэн болон гэрээт ажилчдын дунд биологийн олон янз байдлын болон байгаль орчны сургалт зохион байгуулах);

<b>Биологийн олон янз байдлын мониторинг, үнэлгээний төлөвлөгөө</b>		
Хүчинтэй болох: 2015.12.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е14-PLN-0006-М	Хувилбар: 1.0

- Экосистемийн үйлчилгээний ажлын хэсэг.

Энэхүү төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дараах гадны үндсэн ажлын хэсгүүд оролцоно (өөрөөр хэлбэл энэхүү БОЯБМҮТ-ийн бүрэлдэхүүн хэсгүүдийг чиглүүлэх үүрэгтэй этгээдүүд). Үүнд:

- Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам;
- Тээврийн яам;
- Зэрлэг ан амьтан судлах, хамгаалах төв;
- Зэрлэг ан амьтан хамгаалах нийгэмлэг;
- Гурван талт зөвлөл (ГТЗ).

#### **4. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН ДҮРЭМ ЖУРАМ БОЛОН ЭЭРЭГ АХИУ НӨЛӨӨ ҮЗҮҮЛЭХ ЗОРИЛГО**

ОТ компани нь төслийн үйл ажиллагааны эцсийн үр дүнд өмнийн говийн бүс нутгийн биологийн олон янз байдлыг сайжруулсан байх зорилт тавьсан. Рио Тинто группийн Биологийн олон янз байдлын стратегийг хэрэгжүүлэх хүрээнд ОТ компани нь биологийн олон янз байдалд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулахдаа “нөлөөллийг бууруулах үйл ажиллагааны эрэмбэ дараалал” – ыг дагаж мөрддөг бөгөөд энэ нь Өмнийн говийн бүс нутгийн биологийн олон янз байдалд Эерэг ахиу нөлөө үзүүлэх зорилго юм. ОТ компани нь Рио Тинто группийн стратегийн дагуу, уурхайн хаалт хийх үед энэхүү зорилгыг биелүүлсэн байх зорилт тавьсан хэдий ч төслийн ашиглалтын хугацаанд аль болох эрт ЭАН үзүүлэх боломж бололцоог эрэлхийлнэ. ОТ компани уурхайн ашиглалтын хугацааны туршид ЭАН үзүүлэх зорилтоо нэгэн жигд хэрэгжүүлэх зорилготой. Жил болгон холбогдох үзүүлэлт болгоноор гаргасан ахиц дэвшлийг хүснэгт болон зураг хэлбэрээр оруулах бөгөөд ингэснээр ЭАН үзүүлэх зорилт хэр явцтай хэрэгжиж байгааг ил тод үнэлэх боломжтой болно.

Үүнээс гадна ОТ компани дараах институтээс тавьсан байгаль орчны шаардлагуудыг биелүүлэх шаардлагатай: (Зураг 1)-ээс харна уу.

- 1) Монгол Улсын Засгийн газар;
- 2) Олон Улсын Санхүүгийн Корпораци (ОУСК), Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк (ЕСБХБ) зэрэг далд уурхайн бүтээн байгуулалтыг санхүүжүүлж буй олон улсын зээлдүүлэгч нар (гүйцэтгэлийн тодорхой стандартуудыг биелүүлэх шаардлага тавьдаг);
- 3) Рио Тинто зэрэг бусад оролцогч талууд.

<b>Биологийн олон янз байдлын мониторинг, үнэлгээний төлөвлөгөө</b>		
Хүчинтэй болох: 2015.12.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е14-ПЛН-0006-М	Хувилбар: 1.0

#### 4.1 Бусад удирдлагын төлөвлөгөөтэй уялдах нь

Энэхүү удирдлагын төлөвлөгөө нь биологийн олон янз байдалд үзүүлэх эрсдэлийг удирдан зохицуулах Оюу толгойн арга зүйг нэгтгэн тусгасан багц баримт бичгүүдийн нэг юм (Зураг 1-ээс харна уу). БОННУ-ний тайлангийн Хавсралт 1: Оюу толгой ХХК-ийн Биологийн олон янз байдлын стратеги гэсэн хэсэгт ОТ-н биологийн олон янз байдлын удирдлагын ерөнхий арга зүйг тогтмол тоймлон оруулдаг. Уг хэсэгт дараах баримт бичгүүдийг тогтсон хугацаанд шинэчилж, мэдлэг мэдээллийн менежмент, хөрвөх менежменттэй холбоотой орсон өөрчлөлтүүдийг тусгадаг:

- Оюу толгой ХХК-ийн Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөө (БОЯБУТ) – ОТ Рио Тинтогийн биологийн олон янз байдлын арга хэмжээний төлөвлөгөөг хэрхэн дагаж мөрддөг талаар дэлгэрэнгүй тусгасан. Үүнд төслийн зүгээс нэн тэргүүнд хамгаалах шаардлагатай биологийн олон янз байдлыг тодорхойлж, тухайн биологийн олон янз байдалд үзүүлэх эрсдэлийн үнэлгээг хийдэг. Дараа нь эрсдэлээс зайлсхийх, түүнийг бууруулах замаар тухайн биологийн олон янз байдалд үзүүлэх ноцтой, өндөр эрсдэл бүхий төслийн нөлөөллийг бууруулах аргыг тодорхойлдог;
- Оюу толгой ХХК-ийн Газар хөндөлтөд хяналт тавих, нөхөн сэргээлтийг удирдах төлөвлөгөө (ГХХНСУТ) – нөхөн сэргээлтэд анхаарал хандуулах замаар нэн чухал биологийн олон янз байдалд төслийн газар хөндөх үйл ажиллагаанаас үүдэх нөлөөллийг бууруулах ажлыг илүү нарийвчлалтайгаар авч үздэг;
- Оюу толгой ХХК-ийн Дүйцүүлэн хамгааллын удирдлагын төлөвлөгөө (ДХУТ) – БОЯБУТ, ГХХНСУТ-нд тусгасан бууруулах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсний дараа үлдсэн их хэмжээний нөлөөллийг авч үзэхэд зориулан боловсруулсан биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төслийн хөтөлбөрийг тусгасан;
- Оюу толгой ХХК Эерэг ахиу нөлөө үзүүлэх үйл ажиллагааны урьдчилсан тооцоо (ЭАН үзүүлэх үйл ажиллагааны урьдчилсан тооцоо) – ноцтой болон өндөр эрсдэлтэй нөлөөллөөс биологийн олон янз байдлын урьдчилан тооцоолсон үлдэгдэл эерэг нөлөө, сөрөг нөлөөллийг тооцоолж (зайлсхийж, бууруулсны дараа), нөхөн сэргээлт, дүйцүүлэн хамгааллын төлөвлөсөн эерэг нөлөөыг тооцоолж, ОТ нэн чухал биологийн олон янз байдлын хувьд сөрөг нөлөөгүй/эерэг ахиу нөлөө үзүүлэх зорилгодоо хүрэх үү, хэзээ хүрэх вэ гэдгийг урьдчилан таамаглах зорилгоор сөрөг нөлөөллийг эерэг нөлөөтэй харьцуулдаг;
- Оюу толгой ХХК Биологийн олон янз байдлын, мониторинг үнэлгээний төлөвлөгөө (БОЯБМУТ; энэхүү төлөвлөгөө) – Өмнөговийн нэн чухал биологийн олон янз байдлын төлөв байдлыг үнэлэх, төсөлтэй холбоотойгоор үүсэх нөлөөлөл/дарамт болон нөлөөллийг бууруулах үйл ажиллагааны дараалалын үе шат бүрт төслөөс авах арга хэмжээг үнэлэх мониторингийн талаар дэлгэрэнгүй тусгадаг. Ийн мониторингоор ЭАН үзүүлэх үйл ажиллагааны урьдчилсан тооцооны талаар мэдээлж, төсөл нь тогтоосон хугацаандаа ЭАН үзүүлэх зорилгодоо хүрэх эсэхийг тодорхойлж, БОЯБУТ, ГХХНСУТ, ДХУТ-ний хөрвөх менежментэд санал дүгнэлт өгдөг.

	Рио Тинто		МУ-ын Засгийн газар		Зээлдүүлэгчид (ОУСК, ЕСБХБ, бусад)	
--	-----------	--	---------------------	--	------------------------------------	--

<b>Биологийн олон янз байдлын мониторинг, үнэлгээний төлөвлөгөө</b>		
Хүчинтэй болох: 2015.12.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е14-PLN-0006-М	Хувилбар: 1.0

	Рио Тинтогийн биологийн олон янз байдлын стратеги		Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ		Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ	
От компанийн Байгаль орчин, нийгмийн удирдлагын систем	Уурхайн хаалтын төлөвлөгөө (стратегитэй ижил)		Хуулийн хэрэгжилтийн бүртгэл	Чухал амьдрах орчны үнэлгээ	Нөлөөлөл, нөлөөлөл бууруулах үйл ажиллагааны үнэлгээ	ЭАН үзүүлэх үйл ажиллагааны урьдчилсан тооцоо
Ургамал түүх, амьтан агнах, худалдан борлуулах хууль бус үйл ажиллагааны эсрэг журам			Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (жил тутмын)		Зээлдүүлэгчдийн Биологийн олон янз байдлын үйл ажиллагааны төлөвлөгөө (БОЯБУАТ)	
Газар хөндөх үйл ажиллагааны хяналт, нөхөн сэргээлтийн менежментийн төлөвлөгөө	Тээврийн менежментийн төлөвлөгөө	Усны менежментийн төлөвлөгөө	Биологийн олон янз байдлын менежментийн төлөвлөгөө		Бэлчээр болон амьжиргааг сайжруулах стратеги	
Бусад журмууд (ховор ургамлын журам, нөхөн сэргээлтийн ажлыг дуусгах шалгуур үзүүлэлт гэх мэт)	Нэн чухал биологийн олон янз байдлын мониторингийн төлөвлөгөө	Биологийн олон янз байдлын мониторинг, үнэлгээний төлөвлөгөө		Дүйцүүлэн хамгааллын менежментийн төлөвлөгөө		

**Зураг 1.** Биологийн олон янз байдлын мониторингтой холбоотой баримт бичгийн хоорондын уялдаа холбоо.

<b>Биологийн олон янз байдлын мониторинг, үнэлгээний төлөвлөгөө</b>		
Хүчинтэй болох: 2015.12.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е14-ПЛН-0006-М	Хувилбар: 1.0

## **5. 2015 ОНООС ӨМНӨ ХИЙГДСЭН БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН МОНИТОРИНГ**

Биологийн олон янз байдлыг хамгаалах мөн суурь судалгааны мэдээ, мэдээллийг бүрэн гүйцэд цуглуулах ОТ компаний зорилгийг дэмжихийн тулд 2012 оноос хойш биологийн олон янз байдлын мониторингийн судалгааг хийж ирсэн. Үүнд эн тэргүүнд хамгаалах шаардлагатай биологийн олон янз байдлын бүрэлдэхүүн хэсгүүдийн жам ёсны хувирал өөрчлөлтийн талаар ойлголт мэдлэгтэй болох, суурь судалгаануудыг нэгтгэх, мониторингийн аргачлалыг турших зорилгоор 2013-2014 онд хоёр жилийн хугацаанд хэрэгжүүлсэн Нэн чухал биологийн олон янз байдлын мониторингийн төлөвлөгөө (НЧБОЯБМТ) багтана. НЧБОЯБМТ-нд 37 төрлийн мониторингийн аргачлалыг тусгасан бөгөөд түүний хүрээнд дарамтыг тодорхойлох 27 төрлийн үзүүлэлт, төлөв байдлыг тодорхойлох 18 төрлийн үзүүлэлт, хариу арга хэмжээг тодорхойлох 16 төрлийн үзүүлэлтүүдийг хэмжсэн. Туруутан амьтдын агаарын болон газрын тооллого зэрэг зарим аргачлал нь маш төвөгтэй, цогц ажил байсан. Энэхүү мониторингийн судалгааг ОТ компани болон НЧБОЯБМТ-ний гэрээт гүйцэтгэгчийн 2012, 2013, 2014 оны жилийн тайланд тоймлон харуулсан болно.

Хөрвөх менежментийн зарчимд нийцүүлэн дараах нэмэлт хоёр үнэлгээг мөн хийсэн:

- 1) Зөрүүгийн судалгаа (2013) - ОТ компани, Зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэг (ЗАХН), Зүүн Азийн Тогтвортой Хөгжил (Sustainability East Asia), Биологийн олон янз байдлын дэлхийн зөвлөл (БОЯБДЗ) байгууллагууд НЧБОЯБМТ бүрэн дүүрэн эсэхэд үнэлгээ өгөх зорилгоор зөрүүгийн судалгаа хийсэн. Уг ажлын хүрээнд, ОТ компанийн урьдчилан таамаглаж буй томоохон эерэг болон сөрөг нөлөөллүүд нь Чухал амьдрах орчин гэсэн ангилалд багтаж буй биологийн олон янз байдлын бүрэлдэхүүн хэсгүүд, тэр дундаа Байгалийн амьдрах орчин болон Жороо тоодогт хэрхэн нөлөөлөхийг бүрэн дүүрэн илэрхийлэх үзүүлэлтүүдийг сонгож чадсан эсэхийг шалгасан.
- 2) Аргачлал ба үзүүлэлтийн үнэлгээ (2015) - Хоёр жилийн хугацаанд туршилтын журмаар хэрэгжүүлсэн НЧБОЯБМТ-г хаахын өмнө ОТ компани, ЗАХН, БОЯБДЗ болон бусад түншүүд хамтраад уг төлөвлөгөөний хүрээнд туршсан мониторингийн аргачлалуудыг үнэлсэн. Аргачлалуудыг үнэлэхдээ тэдгээрийн зардал, амжилтгүй болох эрсдэл, таамаглалын оновчтой байдал, статистикийн үнэмшил, практик үнэ цэнэ, хөрвөх менежментэд ашиглахад тохирох эсэх зэрэг олон шалгуур үзүүлэлтүүдийг ашигласан. Эдгээр шалгуур үзүүлэлтүүдийн ихэнх нь амьдралд хэрэгжүүлэхэд сул болон давуу талуудтай байх болно. Үзүүлэлт тус бүрийг үнэн зөв байдал, нарийвчлал, мэдрэмж, түүврийн хэмжээ зэргээр нь үнэлсэн. Үнэлгээний үр дүнд дараагийн 5 жилд хэрэгжүүлэх мониторингийн ажилд ашиглах аргачлалуудын жагсаалтыг гаргасан бөгөөд энэхүү хөтөлбөрт тусгасан.

## **6. МОНИТОРИНГИЙН ХАМРАХ ХҮРЭЭ**

ОТ-н үйл ажиллагаанд мониторинг хийх, мөн байгаль орчны зүгээс үзүүлэх хариу үйлчлэлд мониторинг хийх замаар нөлөөллийн баланс дахь эерэг болон сөрөг нөлөөллийн аль алийг нь харгалзан үзэх замаар ЭАН үзүүлэх үйл ажиллагааны зорилтдоо хүрэхэд нь ОТ компанид дэмжлэг үзүүлэх зорилгоор энэхүү Биологийн олон янз байдлын мониторинг, үнэлгээний төлөвлөгөөг боловсруулсан.

### **6.1 Мониторингийн хугацаа**

ОТ-н биологийн олон янз байдлын мониторингийн хөтөлбөр нь уурхайг хаах (одоогоор 2055 он гэж төлөвлөж байгаа) хүртэл үргэлжилнэ. Амьдрах орчин, төрөл зүйлийн ихэнхэд нь Биологийн олон янз байдлын мониторингийн хамрах хүрээ харьцангуй тогтвортой байх бөгөөд харин хөрвөх менежментийн тэргүүлэх зорилтуудыг багтаах үүднээс тодорхой хугацааны дараа зарим нэг аргачлалыг шинээр нэмэх, өөрчлөх, хасах магадлалтай.




Биологийн олон янз байдлын мониторинг, үнэлгээний төлөвлөгөө		
Хүчинтэй болох: 2015.12.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-E14-PLN-0006-M	Хувилбар: 1.0

### 6.2 Мониторингийн хамрах хүрээ - Газар зүйн

Мониторингийн ажлыг чиглүүлэхийн тулд судалгааны маш олон төрлийн асуудлуудыг авч үзэх шаардлагатай болдог тул энэхүү хөтөлбөр нь газар зүйн төрөл бүрийн хэмжээсийг хамрах шаардлагатай. Биологийн олон янз байдлын зарим нэг онцлогийг ОТ төслийн ойролцоох газруудад нарийн хянаж болох бол өмнийн говийн бүс нутгийн хэмжээнд тархсан биологийн олон янз байдлын бусад онцлогийг хамруулахын тулд илүү өргөн хүрээний мониторинг хийх шаардлагатай. Жишээ нь, Байгалийн амьдрах орчны чанарыг (эсвэл нөхцөлийг) сайжруулах чиглэлээр ОТ-н гаргасан хүчин чармайлт амжилтад хүрсэн эсэхийг хэмжихийн тулд тухайн газар нутгийн хэмжээнд мониторинг хийх шаардлагатай болох ба ингэснээр байгалийн хүчин зүйлсийн (ялангуяа хур тунадас) нөлөөллийг илүү сайн ойлгох боломжтой болно. ОТ компани хулан адууны ажиглалт судалгааг хийхдээ зүүн өмнөд говийн бүс нутгийг нийтэд нь хамруулж байгаа нь үүний нэг жишээ юм (Зураг 2).

**Зураг 2:** Мониторингийн талбайн жишээ – туруутан амьтдын газрын ажиглалт судалгааны талбай.



### 6.3 Мониторингийн хамрах хүрээ – Үзүүлэлтийн төрлүүд

Энэхүү хөтөлбөрт мониторингийн гурван төрлийн үзүүлэлтийг ашигласан:

- Төрөл зүйл, тоо толгой, болон байгалийн бусад нөөцийн төлөв;
- Эдгээр биологийн олон янз байдлын бүрэлдэхүүн хэсгүүдэд хүний үйл ажиллагаанаас (мөн Оюу толгойгоос) үүдэлтэй дарамт;
- Тухайн дарамтад ОТ-н зүгээс авах хариу арга хэмжээ.

ХУУДАС 9 of 27

ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТААС ГАРДУУР БОЛНО. ХАМГИЙН СҮ Ү ЛИЙН ХУВИЛБАРЫГ ПОРТАЛ ЦАХИМ ХУУДСАНААС ХАРНА УУ

ХЭВЛЭСЭН ОГНОО: 2016-10-07

<b>Биологийн олон янз байдлын мониторинг, үнэлгээний төлөвлөгөө</b>		
Хүчинтэй болох: 2015.12.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-E14-PLN-0006-M	Хувилбар: 1.0

#### 6.4 Мониторингийн хамрах хүрээ – Амьдрах орчин, төрөл зүйлс

БОЯБМУТ нь БОЯБУТ-ний Хавсралт 1-д зааж, доорх Хүснэгт 2-т оруулсан амьдрах орчин, төрөл зүйлсийн иж бүрдлийн мониторинг судалгааг хийдэг. Үүнд байгалийн бүх төрлийн амьдрах орчин (бэлчээр), Онцгой амьдрах орчны ангилалд багтах бүрэлдэхүүн хэсгүүд, Оюу толгойн оролцогч талуудын тодорхойлсон бусад эн тэргүүнд хамгаалах шаардлагатай биологийн олон янз байдлын төрөл зүйлс багтана.

### 7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ хамгаалахад зориулсан ХӨРВӨХ МЕНЕЖМЕНТИЙН АРГА зүй


ОТ нь биологийн олон янз байдлыг хамгаалах хөрвөх менежментийн арга зүйг ашигладаг. ОТ нь биологийн олон янз байдлын талаарх мэдлэг ойлголт төгс бус бөгөөд менежментийн нөлөөлөл болон хүний хүчин зүйлсийн нөлөөнөөс үүдэн систем нь өөрөө байнга өөрчлөгддөг болохыг хүлээн зөвшөөрдөг.

Хөрвөх менежментийн нэг зорилт нь энэхүү төлөвлөгөөний хүрээнд эн тэргүүнд хамгаалах шаардлагатай зүйлийн төлөв байдалд сөрөг өөрчлөлт гарсан даруйд уян хатан байдлаар хариу арга хэмжээ авч, амжилт ололт, алдаа дутагдлаасаа маш хурдан суралцах боломж олгох үүднээс шийдлүүдийг ухаалгаар турших явдал юм. Энэ нь дараах үндсэн зарчмуудтай байна:

- Идэвхтэй хөрвөх менежментээр тухайн менежментийн үйл ажиллагааг туршилтын байдлаар зохион байгуулах, ингэхдээ үр дүнг нь тоон үзүүлэлтээр гаргаж авах үүднээс тэдгээр үйл ажиллагааг маш сайн боловсруулсан мониторингийн хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх, ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэхэд тус дөхөм болох үйл ажиллагааг илүүтэй үнэлэхийг тус тус шаарддаг;
- Туршиж буй таамаглалыг харгалзан үзсэний үндсэн дээр менежментийн бодлогыг тодорхойлох, ингэснээр хамгийн чухал боловч хараахан тодорхой болоогүй байгаа асуудлуудыг эн тэргүүнд, маш нягт нямбай турших ёстой.

Мониторингийн үйл ажиллагаа, дүн шинжилгээнд үндэслэн ОТ компани хөрвөх менежментийн арга зүйг хэрэгжүүлнэ (Зураг 3).

**Зураг 3.** Хөрвөх менежментэд хамаарах үйл ажиллагаа, баримт бичгүүдийн уялдаа холбоо



<b>Биологийн олон янз байдлын мониторинг, үнэлгээний төлөвлөгөө</b>		
Хүчинтэй болох: 2015.12.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-E14-PLN-0006-M	Хувилбар: 1.0

ОТ компани мониторингийн хөтөлбөрт хяналтын үнэлгээ тогтмол хийж байх бөгөөд ЭАН үзүүлэх үйл ажиллагааны явцыг тодорхойлох, хөрвөх менежментийн хэрэгцээ шаардлагыг гүйцэлдүүлэх зорилгоор мониторингийн аргачлал болон биологийн олон янз байдлын менежментийн арга зүйд шаардлагатай өөрчлөлтүүдийг тухай бүрт нь оруулж байна. (Хүснэгт 1)

**Хүснэгт 1.** Мониторингийн бүрэлдэхүүн хэсгүүдэд хийх хяналтын үнэлгээний төрлүүд болон давтамж

<b>Хяналтын үнэлгээний ажлууд</b>	<b>Давтамж</b>
Мониторингийн мэдээллийг босго үзүүлэлттэй харьцуулах (дор тайлбарлав)	Шинэ мэдээллийг боловсруулсны дараа нэг сарын дотор. Ихэнх аргачлалын хувьд мэдээлэл боловсруулах ажлыг жилд нэг удаа хийнэ.
Аргачлал, үзүүлэлтэд үнэлгээ хийж, шаардлагатай бол аргачлалд тохиргоо хийх	Хээрийн ажлын улирал эхлэхээс өмнө жилд нэг удаа.
БОЯБМҮТ-г дахин хянах	Аргачлал болон ЭАН үзүүлэх үйл ажиллагааны урьдчилсан тооцоонд хяналт үнэлгээ хийсний дараа жилд нэг удаа*
Мэдээллийг ЭАН үзүүлэх үйл ажиллагааны урьдчилсан тооцоотой харьцуулж, шаардлагатай бол урьдчилсан тооцоонд засвар өөрчлөлт оруулах.	Хээрийн ажлын улирал дууссанаас хойш жилд нэг удаа.
ЭАН үзүүлэх үйл ажиллагааны урьдчилсан тооцоонд бүхэлд нь засвар өөрчлөлт оруулах.	Таван жил тутамд
Хөрвөх менежментийн босго үзүүлэлтэд хяналт үнэлгээ хийж, шаардлагатай бол засвар өөрчлөлт оруулах.	Хээрийн ажлын улирал дууссанаас хойш жилд нэг удаа.
Хөрвөх менежментийн үйл ажиллагаа, туршилтад хяналт үнэлгээ хийж, шаардлагатай бол менежментэд засвар өөрчлөлт оруулах.	Хамгийн багадаа жилд нэг удаа. Арга зүй тохирохгүй болсон (босго үзүүлэлт хэтэрсэн гэх мэт) эсвэл томоохон сайжруулалт хийх боломжтой байна гэсэн баримт нотолгоо байвал нэмэлт хяналт үнэлгээ хийж болно.

\*Зээлдүүлэгчдэд гаргаж өгөх жил тутмын тайлан нь үр дүнгийн тайлан, мөн шинээр цуглуулсан мэдээлэлд үндэслэн өөрчлөлт оруулсан бол үзүүлэлт, аргачлал, босго үзүүлэлтэд оруулсан аливаа өөрчлөлтийн талаарх тайлангаас бүрдэнэ (тайлагналын хэлбэрийг ОТ компани болон зээлдүүлэгч нар харилцан тохиролцох шаардлагатай).

## 8. МОНИТОРИНГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Энэхүү хэсэгт одоо явагдаж буй биологийн олон янз байдлын мониторингийн талаар тоймлон харуулав (Хүснэгт 2). Мониторингийн үр дүн болон бусад мэдээлэлд үндэслэн тодорхой давтамжтайгаар хөрвөж, шинэчилж байх зорилгоор энэхүү төлөвлөгөөг боловсруулсан болно. (Хүснэгт 1)

Мониторингийн нарийвчилсан аргачлалуудыг хавсралтаар оруулсан бөгөөд тухайн аргачлалуудыг хэрэгжүүлэх нарийвчилсан шат дарааллыг тодорхойлсон Ажлын Стандарт Журам (АСЖ) боловсруулах үндэс суурь болно.

<b>Биологийн олон янз байдлын мониторинг, үнэлгээний төлөвлөгөө</b>		
Хүчинтэй болох: 2015.12.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е14-ПЛН-0006-М	Хувилбар: 1.0

**Хүснэгт 2.** Эн тэргүүнд хамгаалах шаардлагатай биологийн олон янз байдлын үзүүлэлтийн тойм (дэлгэрэнгүйг Хавсралтаар харуулав).

Биологийн олон янз байдал	Дарамт, байдал эсхүл хариу арга хэмжээ? ДХУТ АГУ?	Үзүүлэлт (дэлгэрэнгүйг хавсралтаас харна уу)	ЭАН үзүүлэх зорилго (25 жилийн хугацаанд ЭАН үзүүлэх үйл ажиллагаа)	Улбар шар босго үзүүлэлт	Улаан босго үзүүлэлт
<b>1.Нэн чухал амьдрах орчны ангилалд багтах зүйлс</b>					
<b>1а. ОТ-н нөлөөллөөс үүдэлтэй урьдчилан тооцоолсон ноцтой эрсдэл</b>					
Хулан, хар сүүлт	Дарамт (=ДХУТ-АГУ-1)	Хууль бус агнуурын эсрэг дүйцүүлэн хамгаалах нутаг дэвсгэрт (газрын тооллогоор) илэрсэн амьтны сэг зэмийн нягтшил	Амьтны шинэ сэг зэмийн тоо 18%-иар буурсан (2015 оны суурь судалгаагаар)	Өмнөх жилийнхээс өссөн үзүүлэлттэй байх эсвэл 10 жилийн хугацаанд <30% -иар буурсан,	5 жилийн хугацаанд амьтны сэг зэмийн тоо буураагүй.
	Дарамт/Хариу аргахэмжээ (=ДХУТ-АГУ-3)	Дэд бүтэцээс дайжих, зайлсхийх.	Хууль бус ангийн давтамж агнуурын эсрэг ажил хэрэгжүүлсэн газарт 8,5%-иар буурсан.	Үндсэн мэдээлэл бэлэн болоход тогтооно.	Үндсэн мэдээлэл бэлэн болоход тогтооно.
	Дарамт	ОТ-ГС засмал замаар зэрлэг амьтдын хөндлөн гарсан тоо. (GPS-тэй хүзүүвч зүүсэн амьтад)	Жилд засмал замаар хөндлөн гарсан амьтад (20 хүзүүвчтэй хулангаас) Жилд засмал замаар хөндлөн гарсан амьтад (20 хүзүүвчтэй хар сүүлтээс)	Жилд <5 удаа засмал зам хөндлөн гарсан (20 хүзүүвчтэй хулангаас) Жилд <5 удаа засмал зам хөндлөн гарсан (20 хүзүүвчтэй хар сүүлтээс)	Жилд <1 удаа засмал зам хөндлөн гарсан (20 хүзүүвчтэй хулангаас) Жилд <1 удаа засмал зам хөндлөн гарсан (20 хүзүүвчтэй хар сүүлтээс)
	Дарамт	Ургамал түүх, амьтан агнах, хадгалах, тэжээх зэрэг хууль бус үйлдэл үйлдсэн нь нотлогдсон зөрчлийн тоо (хууль сахиулах багаас)	Хэсэг нэгж тус бүрийн ажлаас илрүүлж, бууруулах (2015-2016 оны суурь судалгаанаас)	Үндсэн мэдээлэл бэлэн болоход тогтооно.	Үндсэн мэдээлэл бэлэн болоход тогтооно.
	Дарамт	Ургамал, амьтны хууль бус бүтээгдэхүүн илрүүлсэн ОТ-н	хамаарахгүй	Жагсаалтад багтсан эн тэргүүнд хамгаалах	Жагсаалтад багтсан эн

<b>Биологийн олон янз байдлын мониторинг, үнэлгээний төлөвлөгөө</b>		
Хүчинтэй болох: 2015.12.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е14-ПЛН-0006-М	Хувилбар: 1.0

		үзлэг шалгалтын тоо.		шаардлагатай сүүн тэжээлтэн, шувууны төрөл зүйлийг илрүүлэх үзлэг шалгалт.	тэргүүнд хамгаалах шаардлагатай сүүн тэжээлтэн, шувууны төрөл зүйлийг илрүүлэх үзлэг шалгалт >1
	Дарамт	Айл өрх, орон нутаг, худалдааны төвүүд дэхь судалгаа (үзүүлэлтийг шалгаж байгаа).	Үзүүлэлтийг эцэслэн гаргасны дараа тогтооно.	Үндсэн мэдээлэл бэлэн болоход тогтооно.	Үндсэн мэдээлэл бэлэн болоход тогтооно.
	Дарамт	ОТ компани болон гэрээт компанийн тээврийн хэрэгсэлд мөргүүлсэн зэрлэг ан амьтдын тоо.	хамаарахгүй	Мөргөсөн осол зөрчил гарсан	Улиралд хулан мөргөсөн тоо >1 Улиралд хар сүүлт мөргөсөн тоо >4
	Дарамт	ОТ-н тээврийн хэрэгслийн гаргасан зөрчлийн тоо (хурд хэтрүүлэх, замгүй газраар явах, түр зогсох).	хамаарахгүй	Үндсэн мэдээлэл бэлэн болоход тогтооно.	Үндсэн мэдээлэл бэлэн болоход тогтооно.
	Дарамт	ОТ-ГС засмал замын хөдөлгөөний эрчим, хурд хэтрүүлсэн тээврийн хэрэгслийн тоо.	хамаарахгүй	Үндсэн мэдээлэл бэлэн болоход тогтооно.	Үндсэн мэдээлэл бэлэн болоход тогтооно.
	Төлөв байдал (=ДХУТ-АГҮ-2)	100,000 км <sup>2</sup> талбайд байгаа том хөхтөн амьтдын тоо толгой (газрын тооллогоор).	Илрүүлэх боломжтой өсөлт (p<0.2 2013-2015 оны суурь судалгаанаас).	3 жилийн хугацаанд дундаж бууралт >10%	3 жилийн хугацаанд дундаж бууралт >30%
	Төлөв байдал	100,000 км <sup>2</sup> талбайд байгаа том хөхтөн амьтдын тоо толгой (агаарын тооллогоор). 5 жил тутам.	Илрүүлэх боломжтой өсөлт (2013 оны суурь судалгаанаас).	3 судалгаагаар дундаж бууралт >10% (ойролцоогоор 15 жил)	3 судалгаагаар дундаж бууралт >30% (ойролцоогоор 15 жил)
	Төлөв байдал (=ДХУТ-АГҮ-5)	Өмнийн говийн газар нутаг дахь хулан адууны тархцын хүрээ	УБ-Бээжин төмөр замын зүүн хэсэгт орших 5000 км <sup>2</sup> талбайтай	Төмөр замын өргөст торыг авах туршитын ажилаас хойш 12 сарын хугацаанд	Төмөр торыг бүрэн авснаас хойш 2 жилийн

<b>Биологийн олон янз байдлын мониторинг, үнэлгээний төлөвлөгөө</b>		
Хүчинтэй болох: 2015.12.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е14-PLN-0006-М	Хувилбар: 1.0

			тохиромжтой амьдрах орчин	төмөр замын зүүн тал руу нүүдэл хөдөлгөөн хийгээгүй.	хугацаанд төмөр замаас зүүн тийш нүүдэл хөдөлгөөн хийгээгүй.
	Хариу арга хэмжээ (=ДХУТ-АГҮ-6)	УБ-Бээжингийн төмөр замыг хөндлөн гарсан нийт тохиолдол.	Хоёр зүйл амьтны хувьд нэг сар тутамд төмөр замыг хөндлөн гарсан нийт тохиолдол >10	Төмөр замын өргөст торыг авах туршилтын ажилаас хойш 12 сарын хугацаанд хоёр зүйл амьтныжилд төмөр зам хөндлөн гарсан нийт тохиолдол<5	Төмөр торыг бүрэн авснаас хойш 2 жилийн хугацаанд төмөр зам хөндлөн гараагүй.
	Хариу арга хэмжээ	Сургалтад (жолоочийн) хамрагдсан үндсэн/гэрээт ажилчдын тоо, хувиар	100%	80%	60%
	Хариу арга хэмжээ	Хүн өдрийн тоо (Олон талын төлөөлөл бүхий хамтарсан баг, Хулгайн ан агнууртай тэмцэх хөдөлгөөнт багийн эргүүлд гарсан)	хамаарахгүй	Үндсэн мэдээлэл бэлэн болоход тогтооно.	Үндсэн мэдээлэл бэлэн болоход тогтооно.
	Хариу арга хэмжээ	Бүс нутгийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явц	хамаарахгүй	Үндсэн мэдээлэл бэлэн болоход тогтооно.	Үндсэн мэдээлэл бэлэн болоход тогтооно.

***b.ОТ-н нөлөөлөөс үзүүлэх урьдчилан тооцоолсон өндөр эрсдэл***

Бүйлс, Аргамжинцэцэг, Грубовын хөөндий, Потанины хотир	Дарамт	ОТ-той холбоотой дэд бүтцээс шалтгаалж үхсэн бодгалийн тоо.	ГХТХ, НСУТ-г эцэслэн боловсруулсны дараа тодорхойлно.	ГХТХ, НСУТ-г эцэслэн боловсруулсны дараа тодорхойлно.	ГХТХ, НСУТ-г эцэслэн боловсруулсны дараа тодорхойлно.
	Төлөв байдал	Бодгалийн тоо (байгуулсан бэлчээрийн мониторингийн талбайн хүрээнд)	ОТ-с хамаарч буурсан зүйл байхгүй.(суурь судалгаанаас эсхүл хяналттай харьцуулсан).	Үндсэн мэдээлэл бэлэн болоход тогтооно.	Үндсэн мэдээлэл бэлэн болоход тогтооно.
	Хариу арга хэмжээ	Нөхөн сэргээлт хийсэн бэлчээрийн талбай дахь	Үзүүлэлтийг эцэслэн гаргасны дараа	Үндсэн мэдээлэл бэлэн болоход тогтооно.	Үндсэн мэдээлэл бэлэн болоход

<b>Биологийн олон янз байдлын мониторинг, үнэлгээний төлөвлөгөө</b>		
Хүчинтэй болох: 2015.12.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-E14-PLN-0006-M	Хувилбар: 1.0

		бодгалийн тоо (үзүүлэлтийг шалгаж байгаа).	тогтооно.		тогтооно.

<b>Биологийн олон янз байдлын мониторинг, үнэлгээний төлөвлөгөө</b>		
Хүчинтэй болох: 2015.12.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-E14-PLN-0006-M	Хувилбар: 1.0

<b>1b. ОТ-н нөлөөллөөс үүдэлтэй урьдчилан тооцоолсон бага/дунд зэргийн эрсдэл</b>					
Боржингийн илрэлийн цэцгэн бүлгэмдэл		(Дарамт, төлөв байдлын үзүүлэлтийг шалгаж байгаа).	Үзүүлэлтийг эцэслэн гаргасны дараа тогтооно.	Үндсэн мэдээлэл бэлэн болоход тогтооно.	Үндсэн мэдээлэл бэлэн болоход тогтооно.
Могойч загалай	Дарамт	Тогонд цохиулж үхсэн, цахилгаан шонгийн дэд бүтцийн доор буй зэрлэг амьтдын сэг зэмийн тоо	Тогонд цохиулж үхсэн шувууны сэг зэм байхгүй.	Тогонд цохиулж үхсэн шувууны сэг зэм олдсон	Жилд тогонд цохиулж үхсэн шувууны сэг зэмийн тоо >1
	Дарамт	Цахилгаан шугамтай мөргөлдөж үхсэн, цахилгаан шонгийн дэд бүтцийн доор буй зэрлэг амьтдын сэг зэмийн тоо	Шугам мөргөж үхсэн шувууны сэг зэм байхгүй.	Шугам мөргөж үхсэн шувууны сэг зэм олдсон.	Жилд шугам мөргөж үхсэн шувууны сэг зэмийн тоо >1
	Төлөв байдал	Ханбогд сумын судалгааны талбай дахь идэвхтэй үүрний (шувууны) тоо.	Буураагүй (2013-2015 оны суурь судалгаанаас).	Үндсэн мэдээлэл бэлэн болоход тогтооно.	Үндсэн мэдээлэл бэлэн болоход тогтооно.
	Хариу арга хэмжээ	ОТ-н цахилгааны шугамын дэд бүтэц дагуух ажиллагаагүй болсон, дутсан (алга болсон) шувуу үргээгчийн тоо, хувиар.	хамаарахгүй	хамаарахгүй	хамаарахгүй
	Хариу арга хэмжээ	Тусгаарлагч хийхээр төлөвлөсөн цахилгааны шон, төгсгөлийн шон, дэд станц, цамхагуудад тусгаарлагч суурилуулж, засвар үйлчилгээ хийж буй ажлын гүйцэтгэл, хувиар.	100%	90%	70%



<b>Биологийн олон янз байдлын мониторинг, үнэлгээний төлөвлөгөө</b>		
Хүчинтэй болох: 2015.12.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-E14-PLN-0006-M	Хувилбар: 1.0

	Хариу арга хэмжээ (=ДХУТ-АГҮ-8)	Тусгаарлагчтай ОТ-н бус цахилгааны шугамын урт/км.	ТЭЗҮ-ийн хүрээнд тогтооно.	ТЭЗҮ-ийн хүрээнд тогтооно.	ТЭЗҮ-ийн хүрээнд тогтооно.
<b>2. Бусад оролцогч талуудаас тавьсан шаардлагын дагуу эн тэргүүнд хамгаалах шаардлагатай зүйлс</b>					
<b>2а. ОТ-н нөлөөллөөс үүдэлтэй урьдчилан тооцоолсон өндөр эрсдэл</b>					
Жороо тоодог	Дарамт	Цахилгаан шугамтай мөргөлдөж үхсэн, цахилгаан шугамын дэд бүтцийн доор буй зэрлэг амьтдын сэг зэмийн тоо	Шугам мөргөж үхсэн шувууны сэг зэмийн тоо жилд ≤4.	Шугам мөргөж үхсэн шувууны сэг зэмийн тоо жилд >4.	Шугам мөргөж үхсэн шувууны сэг зэмийн тоо жилд >6.
	Дарамт	Жороо тоодогийн үржлийн үеэр Галбын говийн сав газарт хийгдэх барилга угсралт, засвар үйлчилгээний ажлын тоо.	хамаарахгүй	Хийгдэх ажил үйлчилгээ байгаа.	Нэг жилд, нэг ижил талбайд хийгдэх ажил үйлчилгээний тоо >1 байх.
	Дарамт	ОТ компани болон гэрээт компанийн тээврийн хэрэгсэлд мөргүүлсэн зэрлэг ан амьтдын тоо.	хамаарахгүй	Жороо тоодог мөргөсөн осол гарах.	Жилд жороо тоодог мөргөсөн тоо >1.
	Дарамт	Хог хаягдлын менежментийн төв дэх хэрээний тоо.	хамаарахгүй	Үндсэн мэдээлэл бэлэн болоход тогтооно.	Үндсэн мэдээлэл бэлэн болоход тогтооно.
	Дарамт	Ханбогд сумын судалгааны талбай дахь идэвхтэй хэрээний үүрний тоо.	хамаарахгүй	Үндсэн мэдээлэл бэлэн болоход тогтооно.	Үндсэн мэдээлэл бэлэн болоход тогтооно.
	Төлөв байдал	<i>Дарамтын мониторингийн үр дүнд үндэслэн тоо толгойн нягтаршилд мониторинг хийх хугацаа, аргачлалд жил</i>			

<b>Биологийн олон янз байдлын мониторинг, үнэлгээний төлөвлөгөө</b>		
Хүчинтэй болох: 2015.12.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е14-PLN-0006-М	Хувилбар: 1.0

		<i>бүр хяналт үнэлгээ хийх.</i>			
--	--	-------------------------------------	--	--	--

<b>Биологийн олон янз байдлын мониторинг, үнэлгээний төлөвлөгөө</b>		
Хүчинтэй болох: 2015.12.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-E14-PLN-0006-M	Хувилбар: 1.0

	Хариу арга хэмжээ	ОТ-н цахилгааны шугамын дэд бүтцийн дагуух ажиллагаагүй болсон, дутсан (алга болсон) шувуу үргээгчийн тоо, хувиар.	хамаарахгүй	хамаарахгүй	хамаарахгүй
	Хариу арга хэмжээ (=ДХУТ-АГҮ-7)	Үндэсний шинэ стандарт гарснаас хойш Монгол Улсын нутаг дэвсгэр дээр баригдсан ОТ-н бус цахилгааны шугамын урт, км.	Цахилгааны шугамын стандартыг тохиролцсоны дараа тогтооно.	Цахилгааны шугамын стандартыг тохиролцсоны дараа тогтооно.	Цахилгааны шугамын стандартыг тохиролцсоны дараа тогтооно.
Бусад эн тэргүүнд хамгаалах ургамал	Бэлчээрийн амьдрах орчин алдагдах, бэлчээр доройтсоноос үүсэх болзошгүй нөлөөлөл: Онцгой амьдрах орчны ангилалд багтах эн тэргүүнд хамгаалах шаардлагатай ургамалтай ижил аргачлал (дээр дурдсан); өндөр заган ойтой ижил аргачлал (доор харуулав) ашиглана.				

**2b. ОТ-н нөлөөллөөс үүдэлтэй урьдчилан тооцоолсон бага/дунд зэргийн эрсдэл**

Голын хайлаас, улиангар	Дарамт	Булаг шанд, моддын ойр орчим дах усны урсац	Хяналтын талбайтай харьцуулахад ОТ-н нөлөөлөлд өртсөн талбайд ноцтой өөрчлөлт гараагүй.	Хэмжилтийн хугацааны гүний усны түвшний өөрчлөлт (нэмэгдэхэсвэл буурах) >2 удаагийн хэмжилтээр	Хэмжилтийн хугацааны гүний усны түвшний өөрчлөлт (нэмэгдэх эсвэл буурах) >4 удаагийн хэмжилтээр
	Дарамт	Дэд бүтцийн улмаас үхсэн модны тоо	Нэмж үхээгүй.	Мод үхсэн	Аливаа хоёр мод үхсэн.
	Төлөв байдал	Хайлаасны титмийн үхсэн %	Хяналтын талбайтай харьцуулахад ОТ-н нөлөөлөлд өртсөн талбайд ноцтой өөрчлөлт гараагүй.	Дурын жилийн хяналтын талбайтай харьцуулахад ОТ-н нөлөөлөлд өртсөн талбайд хайлаасны титмийн үхсэн хувийн дундаж өсөлт >5%	Дурын жилийн хяналтын талбайтай харьцуулахад ОТ-н нөлөөлөлд өртсөн талбайд хайлаасны титмийн үхсэн хувийн дундаж өсөлт >20%
	Хариу арга хэмжээ	Тарьсан хайлаасны тоо,	хамаарахгүй	хамаарахгүй	хамаарахгүй

<b>Биологийн олон янз байдлын мониторинг, үнэлгээний төлөвлөгөө</b>		
Хүчинтэй болох: 2015.12.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-E14-PLN-0006-M	Хувилбар: 1.0

		ургалтын хувь			
Байгалийн амьдрах орчин/бэлчээрийн талбай	Дарамт	ОТ-н дэд бүтцээс шалтгаалж доройтсон талбай	Урьдчилан тооцоолсон нөлөөлөл нь 8500QH-с ихгүй.	Үндсэн мэдээлэл бэлэн болоход тогтооно.	Үндсэн мэдээлэл бэлэн болоход тогтооно.
	Дарамт	ОТ-н тээврийн хэрэгслийн гаргасан зөрчлийн тоо (хурд хэтрүүлэх, замгүй газраар явах, түр зогсох)	хамаарахгүй	Үндсэн мэдээлэл бэлэн болоход тогтооно.	Үндсэн мэдээлэл бэлэн болоход тогтооно.
	Дарамт	Бэлчээр ашиглалтын дундаж түвшин (хашаалсан талбайн гаднах болон доторх өөрчлөлтийг харьцуулах)	хамаарахгүй	Үндсэн мэдээлэл бэлэн болоход тогтооно.	Үндсэн мэдээлэл бэлэн болоход тогтооно.
	Дарамт	Тээврийн хэрэгслийн гаргасан салаа замуудын нягтаршил, хэв маяг (үзүүлэлтүүдэд хяналт үнэлгээ хийж байгаа)	Талбайд бага зэрэг нэмэгдсэн (2013 оны суурь судалгаанаас)	Үндсэн мэдээлэл бэлэн болоход тогтооно.	Үндсэн мэдээлэл бэлэн болоход тогтооно.
	Төлөв байдал/Хариу арга хэмжээ (=ДХУТ-АГҮ-4)	Бэлчээрийн чанар (байгуулсан бэлчээрийн мониторингийн талбайн хүрээнд)	350,000 га талбайд 3,75% сайжирсан (хяналтын талбайтай харьцуулахад).	Үндсэн мэдээлэл бэлэн болоход тогтооно.	Үндсэн мэдээлэл бэлэн болоход тогтооно.
	Хариу арга хэмжээ	Нөхөн сэргээсэн бэлчээрийн талбай, бэлчээрийн чанар (үзүүлэлтүүд хяналт үнэлгээ хийж байгаа)	8500 чанар га (QH)-ийн урьдчилан тооцоолсон нөлөөллийн 50%.	Үндсэн мэдээлэл бэлэн болоход тогтооно.	Үндсэн мэдээлэл бэлэн болоход тогтооно.
	Хариу арга хэмжээ	Ноолуурын төслийн талбай дахь ямааны (болон бусад малын) тоо толгойн нягтшил	Ямааны тоо толгойн бууралтын хувийг 2017 онд тогтооно.	2017 онд тогтооно.	2017 онд тогтооно.
	Хариу арга хэмжээ	Замын дагуух орон нутгийн иргэдийн түүсэн хог хаягдлын	хамаарахгүй	хамаарахгүй	хамаарахгүй

<b>Биологийн олон янз байдлын мониторинг, үнэлгээний төлөвлөгөө</b>		
Хүчинтэй болох: 2015.12.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е14-PLN-0006-М	Хувилбар: 1.0

		тоо, уутаар			
Аргаль	Дарамт	Хууль бусаар ургамал түүсэн, амьтан агнасан, хадгалсан талаар мэдээлсэн зөрчлийн тоо (хууль сахиулах багаас).	Илрүүлж болох бууралт (2015-2016 оны суурь судалгаанаас)	Үндсэн мэдээлэл бэлэн болоход тогтооно.	Үндсэн мэдээлэл бэлэн болоход тогтооно.
	Дарамт	Айл өрх, орон нутаг, зах зээлийн судалгаа (үзүүлэлтүүдэд хяналт үнэлгээ хийж байгаа).	Үзүүлэлтийг эцэслэсний дараа тогтооно.	Үндсэн мэдээлэл бэлэн болоход тогтооно.	Үндсэн мэдээлэл бэлэн болоход тогтооно.
	Дарамт	Ургамал, амьтны хууль бус бүтээгдэхүүн илрүүлсэн ОТ-н үзлэг шалгалтын тоо.	хамаарахгүй	Үндсэн мэдээлэл бэлэн болоход тогтооно.	Үндсэн мэдээлэл бэлэн болоход тогтооно.
	Төлөв байдал	100,000 км <sup>2</sup> талбайд байгаа том хөхтөн амьтдын тоо толгой (агаарын тооллогоор)	Илрүүлж болох өсөлт (2013 оны суурь судалгаанаас)	3 судалгааны хугацааны дундаж бууралт >10% (ойролцоогоор 15 жил)	3 судалгааны хугацааны дундаж бууралт >30% (ойролцоогоор 15 жил)
	Хариу арга хэмжээ	Хураасан зэрлэг ан амьтны бүтээгдэхүүний үнийн дүн (уурхайн цогцолборт хийгдсэн ОТ-н үзлэг шалгалтаар).	хамаарахгүй	Үндсэн мэдээлэл бэлэн болоход тогтооно.	Үндсэн мэдээлэл бэлэн болоход тогтооно.
Цагаан зээр		Хар сүүлт зээртэй ижил нөлөөлөлд өртөх боловч нөлөөллийн талбайд цөөн тохиолдоно. Хар сүүлт зээртэй ижил аргачлал, зорилт, босго үзүүлэлт хэрэглэгдэнэ (дээр дурдсан).			
Алагдаахай, эрээн хүрэн, Козловын харуулдай		Нөлөөллийн талбайд бүртгэл, судалгаа хийгдээгүй тул мониторинг төлөвлөөгүй.			
Гангар хун, Ундар шумбуур, идлэг шонхор, ооч ёл, хонин тоодог, реликт цахлай, борцгор хотон		Цахилгааны шугамаас үзүүлж болзошгүй нөлөөлөл; могойч загалай, жороо тоодогтой ижил арга, зорилт, босго үзүүлэлттэй байна (дээр харуулсан).			

<b>Биологийн олон янз байдлын мониторинг, үнэлгээний төлөвлөгөө</b>		
Хүчинтэй болох: 2015.12.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е14-PLN-0006-М	Хувилбар: 1.0

Монгол ногтруу, Монгол хулан жороо		Цахилгааны шугамаас үзүүлж болзошгүй нөлөөлөл; могойч загалай, жороо тоодогтой ижил арга, зорилт, босго үзүүлэлттэй байна (дээр харуулсан). Бэлчээрийн амьдрах орчин алдагдах, доройтохоос үүдэлтэй болзошгүй нөлөөлөл: бэлчээрийн мониторингийн аргатай ижил аргачлал хэрэглэнэ (дээр харуулсан).
--	--	--

**2с. ОТ-н нөлөөллөөс үүдэлтэй урьдчилан тооцоолсон маш бага эрсдэл**

Улирлын чанартай нуур, цөөрөм		Нөлөөллийн талбайд улирлын чанартай нуур, цөөрөм үүсэх хүртэл мониторингийн ажил төлөвлөөгүй.
Шар элэгт хөмрөг		Нөлөөллийн талбайд бүртгэл, судалгаа хийгдээгүй тул мониторинг төлөвлөөгүй.

<b>Биологийн олон янз байдлын мониторинг, үнэлгээний төлөвлөгөө</b>		
Хүчинтэй болох: 2015.12.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е14-ПЛН-0006-М	Хувилбар: 1.0

## 9. МОНИТОРИНГИЙН ЗОРИЛТ, БОСГО ҮЗҮҮЛЭЛТҮҮД

### 9.1 ЭАН үзүүлэх үйл ажиллагааны зорилтууд

Ихэнх үзүүлэлтийн хувьд ЭАН үзүүлэх үйл ажиллагааны зорилтыг тоон үзүүлэлтээр илэрхийлсэн. Энэ нь ЭАН үзүүлэх үйл ажиллагааны урьдчилсан тооцоонд тусгасан тооцоот үр дүнд хүрэх тухай асуудал юм. Хангалттай мэдээлэлтэй болох үед дунд хугацааны (5-10 жил) нэмэлт зорилтуудыг боловсруулах боломжтой. Зарим үзүүлэлтүүдийг ЭАН үзүүлэх үйл ажиллагааны урьдчилсан тооцоонд оруулаагүй, учир нь тодорхой бус бусад том нөлөөлөлүүдтэй харьцуулхад тэд тоон үзүүлэлтийн хувьд хангалттай нөлөө үзүүлдэггүй. Жишээ нь, “ОТ-н тээврийн хэрэгслийн гаргасан зөрчлийн тоо (хурд хэтрүүлсэн, замгүй газраар явсан, түр зогссон)” нь төслийн үл мөрөөс шалтгаалсан амьдрах орчны сөрөг нөлөө болон хууль бус ан агнуураас үүдэлтэйгээр ан амьтад тээврийн хэрэгслээс үргэж, дайжих зэрэгтэй харьцуулахад тоогоор илэрхийлэгдэх нөлөөлөл бага хэдий ч уг үзүүлэлт нь ОТ болон төслийн оролцогч талуудын хувьд энэ нь шийдвэрлэж, хянах шаардлагатай чухал асуудал хэвээр байх юм. Бусад үзүүлэлтүүд нь “өгөгдөл үзүүлэлт” (жишээ нь, Олон талын төлөөлөл бүхий хамтарсан баг, Хулгайн ан агнууртай тэмцэх хөдөлгөөнт багийн эргүүлд гарсан хүн, өдрийн тоо гэх мэт) болно. Гэхдээ ихэнх орцын үзүүлэлтүүдийг энэхүү БОЯБМҮТ бус, харин БОЯБМТ эсвэл ЯАМТ-ний хүрээнд баримтжуулсан, зарим нэгийг нь (дээр дурдсан жишээ зэрэг) хөрвөх менежмент болон гадагш өгөх мэдээлэлд оруулах нь чухал гэж үзсэн.

Зорилт, босго үзүүлэлтүүдийг тогтоохдоо тогтвортой суурь судалгаа (өөрөөр хэлбэл ОТ-н бус нөлөөлөлд өөрчлөлт орохгүй гэсэн нөхцөлд)-нд үндэслэсэн бөгөөд мониторинг, бусад судалгааны мэдээнд анализ хийж, суурь судалгааг баталгаажуулна.

### 9.2 Хөрвөх менежментийн босго үзүүлэлтүүд

“Төлөв байдал”-ыг тодорхойлох үзүүлэлтүүд нь ЭАН үзүүлж байгааг харуулах тул ерөнхийдөө өсөх хандлагатай байх шаардлагатай. Зарим тохиолдолд (Жороо тоодог болон эн тэргүүнд хамгаалах шаардлагатай ховор ургамал хууль бусаар түүснээр болон хороосноор нөлөөлөлд өртөөгүй тохиолдлууд гэх мэт) төлөв байдлыг сайжруулах нь практикт боломжгүй байж болох тул төлөв байдалтай холбоотой зорилт нь өөрчлөлтгүй байх бөгөөд хариу арга хэмжээг илэрхийлэх нэмэлт үзүүлэлтийг ашиглан дүйцүүлэн хамгаалал болон/эсвэл нөхөн сэргээлтийн үйл ажиллагаанаас гарсан зэрэг нөлөөллийг хянана. “Дарамт”-ыг илэрхийлэх үзүүлэлт нь ерөнхийдөө буурах хандлагатай байх шаардлагатай. Зарим тохиолдолд (тухайлбал төслийн шууд үл мөрийн хувьд) ЭАН үзүүлэх үйл ажиллагааны урьдчилсан тооцоонд нэгэнт тусгасан нөлөөллүүдээс өөр нэмэлт нөлөөлөл үүсгэхгүй байх зорилт тавьсан. “Хариу арга хэмжээ”-г илэрхийлэх үзүүлэлтүүд нь ерөнхийдөө өсөх хандлагатай байх шаардлагатай. Хариу арга хэмжээ нь “өгөгдөл үзүүлэлт” бөгөөд дарамт болон төлөв байдлыг илэрхийлэх үзүүлэлтэд үзүүлж буй нөлөөллөөр нь дамжуулан хянахад илүү тохиромжтой тул хариу арга хэмжээний үзүүлэлтүүдэд зорилт дэвшүүлэх нь төдийлөн тохиромжтой бус юм. (“Өгөгдөл”-ын үзүүлэлтүүдийг Дүйцүүлэн хамгааллын менежментийн төлөвлөгөөнд тусгасан)

Мониторингийн ажлын үр дүнд дүн шинжилгээ хийх үед босго үзүүлэлтийг анхааруулах дохио болгон ашигладаг. Босго үзүүлэлтийг давсан тохиолдолд тухайн үзүүлэлтийг давахад хүргэсэн сөрөг нөлөөллийг ОТ компанийн эсвэл гадны жолооч үзүүлсэн эсэхийг тодорхойлох хяналт шинжилгээг эхлүүлнэ. Уг хяналт шинжилгээгээр ОТ-н үйл ажиллагаанаас шалтгаалсан нь тогтоогдвол одоогийн менежментийг өөрчлөх шаардлагатай эсэхийг шалгах зорилгоор нэмэлт хяналт шинжилгээ хийнэ. Мониторинг хийх үүрэг бүхий талууд босго үзүүлэлтийг давсан эсэхийг тодруулах мониторинг судалгааг жил бүр хийнэ. Гэхдээ зарим тохиолдолд (тухайлбал тээврийн хэрэгслээр хулан адуу дайрсан тохиолдолд) босго үзүүлэлтийг давсан эсэхийг тэр дор нь тогтоож болдог. Босго үзүүлэлтийг давсан тохиолдолд дараах үйл явцыг мөрдөнө:

Хөрвөх менежментийг дэмжих үүднээс босго үзүүлэлт нь:

- Тодорхой утга, цаг хугацааны хязгаартай байх; бөгөөд
- Богино хугацаанд томоохон өөрчлөлт гарсан эсвэл тогтвортой өсөлттэй явсаар урт хугацаанд томоохон өөрчлөлт бий болсон тохиолдолд энэ талаар анхааруулах үүрэгтэй.


Биологийн олон янз байдлын мониторинг, үнэлгээний төлөвлөгөө		
Хүчинтэй болох: 2015.12.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е14-ПЛН-0006-М	Хувилбар: 1.0

Хоёр түвшин бүхий босго үзүүлэлтийг ашиглах бөгөөд тэдгээрийг **Error! Reference source not found.**4-т харуулав. Босго үзүүлэлтийг хэтэрсэн тохиолдолд дараах арга хэмжээг авна. Үүнд:

- Улбар шар босго хэтэрсэн тохиолдолд учир шалтгааныг нь тодорхойлох зорилгоор нэмэлт судалгааг эхлүүлнэ. ОТ компани ЭАН үзүүлэх үйл ажиллагааны зорилтоо хэвийн явцтайгаар биелүүлэхийн тулд одоо хэрэгжүүлж буй нөлөөлөл бууруулах үйл ажиллагаандаа өөрчлөлт оруулах шаардлагатай болж болзошгүй.
- Улаан босго хэтэрсэн тохиолдолд учир шалтгааныг нь ойлгож, ямар хариу арга хэмжээ авах шаардлагатай болохыг тодруулах зорилгоор яаралтай нэмэлт судалгааг эхлүүлэх бөгөөд уг судалгаанд ОТ компаниас томилсон хөндлөнгийн хоёр хянагч хяналт үнэлгээ хийнэ. Нөлөөлөл бууруулах үйл ажиллагаанд өөрчлөлт оруулахгүйгээр, тухайлбал дүйцүүлэн хамгааллын нэмэлт арга хэмжээ авахгүйгээр, ЭАН үзүүлэх үйл ажиллагааны тооцоот зорилтыг биелүүлэх боломжгүй болж болзошгүй.

Эдгээр босго үзүүлэлтийг Хавсралтад жагсаасан бөгөөд аливаа үзүүлэлтийн хэмжээ хэлбэлзэж болох ба шар босго хэтэрсэн тохиолдолд судалгаа эхлүүлэх, харин улаан босго хэтэрсэн тохиолдолд яаралтай судалгаа эхлүүлнэ. Энэхүү судалгаанд үндэслэн нөлөөлөл бууруулах үйл ажиллагааг өөрчлөх шаардлагатай болно. Үзүүлэлт улбар шар босгоос дээгүүр байгаа тохиолдолд ЭАН үзүүлж чадна (өөрөөр хэлбэл төсөл хэвийн явцтай байгаа) гэж үзэх хэдий ч үзүүлэлтүүд улбар шар болон улаан босгоос доогуур болсон тохиолдолд ЭАН үзүүлж чадахгүй байх эрсдэл бий. ЭАН үзүүлэх үйл ажиллагааны урьдчилсан тооцоог болгоомжтой байдлаар гаргасан тул улбар шар босгыг давснаар ЭАН үзүүлж чадахгүй байх эрсдэл үүсэх хэдий ч энэ нь томоохон эрсдэл биш байх юм.

**Зураг 4:** ЭАН үзүүлэх үйл ажиллагааны босго үзүүлэлт, хариу арга хэмжээ, үр дагаврын схем.



ОТ-н биологийн олон янз байдлын ихэнх үзүүлэлтэд (ялангуяа төлөв байдлын үзүүлэлтэд) нөлөөлж буй жам ёсны хувирал өөрчлөлтийн хэмжээ болон хэмжилтийн алдааг хангалттай сайн тодорхойлж хараахан амжаагүй байгаа тул бүлгэмдлийн чиг хандлагад суурилсан, баттай нотолгоо бүхий босго үзүүлэлт гаргах боломжгүй байна. “Төлөв байдал”-ыг илэрхийлэх олон үзүүлэлтүүдийн хувьд суурь үзүүлэлтийг тооцоолохын тулд дор хаяж гурван жилийн турш стандарт мониторинг судалгаа тууштай хийх шаардлагатай байдаг бол бүлгэмдлийн жам ёсны өөрчлөлтийг ойлгож, түүнд гарсан гэнэтийн болон алгуур өөрчлөлтийг ойлгоход түүнээс ч их хугацаа шаардагдана. Мониторингийн судалгааны арга зүйд өөрчлөлт орсоор байгаа тул зарим үзүүлэлтээр гурван жилийн стандарт мониторинг хийгдээгүй байна.



<b>Биологийн олон янз байдлын мониторинг, үнэлгээний төлөвлөгөө</b>		
Хүчинтэй болох: 2015.12.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е14-ПЛН-0006-М	Хувилбар: 1.0

Мэдээлэлтэй болох хүртэл босго үзүүлэлтийг болгоомжтой байдлаар гаргасан байгаа бөгөөд мэргэжлийн санал дүгнэлтэд үндэслэнэ. Эдгээр босго үзүүлэлтийг урьдчилсан үзүүлэлт гэж үзэх шаардлагатай бөгөөд цаашид тодорхой давтамжтайгаар нарийвчилсан хяналт үнэлгээ хийж, ингэхдээ мониторингийн зорилтот болон хөрвөх хөтөлбөрөөс гарсан мэдээллийг (гурван жилийн стандарт мониторингийн баттай мэдээлэл гэх мэт) ашиглана. Эдгээр урьдчилсан босго үзүүлэлтийг гаргахдаа тодорхой жилүүдийн болон урт хугацааны стандарт мэдээллийг харьцуулсны үндсэн дээр (тогтвортой эхлэлийн болон төгсгөлийн цэггүй “хөдөлгөөнт боломж”-оос гарсан хамгийн дээд хязгаарын өөрчлөлт) гаргаж авсан.

Хөрвөх менежментийн үйл ажиллагааг эхлүүлэхэд ашиглаж байгаа босго үзүүлэлтүүд нь ерөнхийдөө “дарамт” үзүүлэлтүүд дээр суурилсан бөгөөд ОТ компанийн ЭАН үзүүлэх үйл ажиллагаа хэвийн явцтай байгаа эсэх, эсвэл ЭАН үзүүлэх үйл ажиллагааны зорилт, уг тооцоот зорилтыг тодорхойлоход ашигласан суурь таамаглал нь мониторингийн мэдээлэлтэй зөрчилдөж байгаа эсэхийг тодорхойлох зорилготой юм. “Төлөв байдал”-ыг илэрхийлэх үзүүлэлтүүдтэй харьцуулахад мониторинг хийх зардал бага, өөрчлөлтийг илүү хурдан илрүүлэх боломжтой, ОТ-н үйл ажиллагаатай хамаатуулахад илүү хялбар байх тул дарамтын үзүүлэлтүүд илүү ач холбогдолтой байдаг. Дарамтын үзүүлэлтүүд нь ОТ-н сөрөг нөлөөллүүдийг хэмжээд зогсохгүй хууль бус ан агнуурын эрчим зэрэг суурь (төсөл эхлэхээс өмнө байсан эсвэл төсөл эхлээгүй бол тэр хэвээрээ үлдэх байсан) дарамтуудыг бууруулж буй эерэг суурь нөлөөллүүдийг мөн хэмжих боломжтой. “Дарамт” болон “төлөв байдал”-ыг илэрхийлэх үзүүлэлтүүдийн уялдаа холбоо сайн мэдэгдэхгүй (тодорхой бус байгаа дарамтын улмаас төлөв байдал өөрчлөгдөж байж болзошгүй гэх мэт) байж болох тул эн тэргүүнд хамгаалах шаардлагатай биологийн олон янз байдлын бүрэлдэхүүн хэсэг болгоноор төлөв байдлын үзүүлэлтүүдийг хянах шаардлагатай бөгөөд босго үзүүлэлтийг аль болох даруйхан тодорхойлно. Мэдээлэлтэй болмогц босго үзүүлэлтүүдийг сайжруулж, шинэ босго үзүүлэлтүүдийг нэмж болох хэдий ч босго үзүүлэлтэд хүрсэн гэсэн цорын ганц үндэслэлээр өөрчлөлт оруулж болохгүй.

ОТ төсөл ЭАН үзүүлэх үйл ажиллагааны зорилтдоо хүрч чадахгүй байж болох эрсдэл үүсэж эхлэх түвшинг заах зорилгоор улбар шар, улаан босгыг тавьсан. Эдгээр босго нь бодит байдал ЭАН үзүүлэх үйл ажиллагааны урьдчилсан тооцоонд ашигласан суурь таамаглал эсвэл дарамт болон төлөв байдлыг илэрхийлэх утгуудаас хэтэрхий холдож байгааг харуулна. “Өгөгдөл үзүүлэлт”-ийг гэрээ болон ажлын төлөвлөгөөнүүдэд тусгаж, хэрэгжилтийн тайлангаар хянаж байгаа тул хариу арга хэмжээний үзүүлэлтэд босго тавиагүй. Хариу арга хэмжээг илэрхийлэх “үр дүнгийн үзүүлэлт” нь дарамтын үзүүлэлт (тухайлбал агнуурын ач холбогдолтой төрөл зүйлүүдэд тавьсан дарамтын үзүүлэлтэд мониторинг хийх замаар хууль бус ан агнуурын эсрэг дүйцүүлэн хамгаалах ажлын үр дүнг хянана гэх мэт) эсвэл төлөв байдлын үзүүлэлт (бэлчээрийн газар нутаг болон уг газар нутагт ургадаг ховор ургамлын төрөл зүйлүүдэд тавьсан төлөв байдлын үзүүлэлтүүдэд мониторинг хийх замаар бэлчээрийн дүйцүүлэн хамгаалах ажлын үр дүнг хянана гэх мэт)-тэй ерөнхийдөө ижил байна.

**Босго давсан үед авах хөрвөх менежментийн үйл ажиллагаа, хариу арга хэмжээ**

Холбогдох үзүүлэлт шар босгыг давсан тохиолдолд биологийн олон янз байдалд эрсдэл тулгарсныг заах бөгөөд хөрвөх менежментийн үйл ажиллагааг эхлүүлнэ. Хариу арга хэмжээ авах үйл явц:

1. Илэрсэн асуудлыг бататгах үүднээс анхан шатны мэдээллийг дахин нягталж шалгах;
2. Ямар үйл явдал тохиолдов, яагаад тохиолдов гэдгийг тодруулах үүднээс мэдээллийг бусад мэдээлэлтэй харьцуулах (босго үзүүлэлтийг давсан нь ОТ компаниас шалтгаалав уу, гадны жолоочоос шалтгаалав уу, эдгээрийн аль аль нь байв уу гэх мэт);
3. Нөлөөлөл бууруулах үйл ажиллагаа үр дүнтэй байсан эсэхэд үнэлгээ өгөх:
  - a. Үр дүнгүй байсан бол нөлөөлөл бууруулах үйл ажиллагааг зохих ёсоор хэрэгжүүлж байсан бол босго үзүүлэлтийг давах байсан уу? Засч залруулах арга хэмжээ авах шаардлагатай. ЭСВЭЛ
  - b. Нөлөөлөл бууруулах үйл ажиллагааг зохих ёсоор хэрэгжүүлсээр байсан хэдий ч босго үзүүлэлтийг давсан бол тухайн нөлөөлөл бууруулах үйл ажиллагаа нь анх төлөвлөсөн шиг үр дүнтэй байгаагүй эсвэл ОТ компанийн хяналтаас гадуур, гадны

<b>Биологийн олон янз байдлын мониторинг, үнэлгээний төлөвлөгөө</b>		
Хүчинтэй болох: 2015.12.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е14-ПЛН-0006-М	Хувилбар: 1.0

жолоочоос шалтгаалсан. Тухайн босго үзүүлэлт хэтэрсэн нь ОТ-н үндсэн болон дам нөлөөлөлтэй холбоотой бол нэмэлт/өөр төрлийн нөлөөлөл бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай.

4. Босго үзүүлэлтийг дахин тохируулах шаардлагатай эсэхийг авч үзэх.

Улаан босгыг давсан тохиолдолд авах арга хэмжээ нь дээрхтэй ижил байх бөгөөд дээр нь НЭМЭЭД:

- Босго үзүүлэлт хэтэрсэн тухай ОТ компани олж мэдсэнээс хойш нэг сарын дотор эдгээр үнэлгээг хийнэ;
- Эдгээр үнэлгээнд ОТ-оос томилсон хөндлөнгийн хянагчаар хяналт үнэлгээ хийлгэнэ;
- Босго үзүүлэлт хэтэрсэн нь ОТ-н үндсэн болон дам нөлөөллөөс шалтгаалсан бол энэ талаар ОТ компани олж мэдсэнээс хойш нэг сарын дотор засч залруулах эсвэл нэмэлт/өөр төрлийн нөлөөлөл бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

### **9.3 Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө, нөлөөлөл бууруулах үйл ажиллагаа**

Нөлөөлөл бууруулах болон дүйцүүлэн хамгаалах үйл ажиллагаа нь ЭАН үзүүлэх үйл ажиллагааны зорилгод хүрэхээр амжилттай хэрэгжиж байгаа эсэхийг тодорхойлохын тулд тодорхой мониторинг хийх шаардлагатай. Менежментийн шинэ арга зүйг турших эсвэл одоо байгаа арга зүйд өөрчлөлт оруулах үед мониторингийн хэрэгцээ шаардлага өөрчлөгдөж болзошгүй. Иймд мониторинг болон нөлөөлөл бууруулах/дүйцүүлэн хамгаалах үйл ажиллагааны хоорондох хэлхээ холбоог энэхүү төлөвлөгөөнд тусгаж өгсөн. Нөлөөлөл бууруулах болон дүйцүүлэн хамгаалах үйл ажиллагааны бүх гэрээ, ажлын төлөвлөгөөнд “өгөгдөл үзүүлэлт”-д мониторинг хийх, түүнийг тайлагнах үйл явц багтсан. Хариу арга хэмжээний “үр дүнгийн үзүүлэлт” нь дарамтын үзүүлэлт (тухайлбал агнуурын ач холбогдолтой төрөл зүйлүүдэд тавьсан дарамтын үзүүлэлтэд мониторинг хийх замаар хууль бус ан агнуурын эсрэг дүйцүүлэн хамгаалах ажлын үр дүнг хянана гэх мэт) эсвэл төлөв байдлын үзүүлэлт (бэлчээрийн газар нутаг болон уг газар нутагт ургадаг ховор ургамлын төрөл зүйлүүдэд тавьсан төлөв байдлын үзүүлэлтүүдэд мониторинг хийх замаар бэлчээрийн дүйцүүлэн хамгаалах ажлын үр дүнг хянана гэх мэт)-тэй ерөнхийдөө ижил байна. Босго хэтэрсэн үед эсвэл өөр бусад шалтгаанаар (зохион байгуулалт, зардал мөнгөний асуудал гарсан, оролцогч талаас шаардлага тавьсан, улирлын чанартай шалтгаанаар гэх мэт) менежментийн стратегийг хугацаанаас нь өмнө үнэлэх шаардлагатай болсноос бусад тохиолдолд эдгээр мониторингийн мэдээллүүдийг ашиглан менежментийн үйл ажиллагаанд жилд нэг удаа хяналт үнэлгээ хийнэ. Эдгээр хяналт үнэлгээний үр дүнг тусгах замаар нөлөөлөл бууруулах болон дүйцүүлэн хамгаалах үйл ажиллагааг сайжруулах, БОЯБМУТ болон ЭАН үзүүлэх үйл ажиллагааны урьдчилсан тооцоог шинэчлэхэд ашиглана.

### **9.4 ЭАН үзүүлэх үйл ажиллагааны төлөвлөлт, урьдчилсан тооцоог шинэчлэх**

ОТ компани Эерэг ахиу нөлөө үзүүлэх боломжтой тухай урьдчилсан тооцоог 2012 онд гаргасан БОННУ-нд анх тусгаж, 2015 онд уг үнэлгээг шинэчилсэн. ЭАН үзүүлэх үйл ажиллагааны урьдчилсан тооцоо нь ОТ-н ерөнхий төлөвлөгөөний маш чухал хэсэг бөгөөд байгаль орчны өөрчлөлт болон/эсвэл шинэ мэдээлэл гарах бүрт тогтмол хянан засварлаж байна. Уг урьдчилсан тооцоо нь эн тэргүүнд хамгаалах шаардлагатай биологийн олон янз байдлын бүрэлдэхүүн хэсгүүдэд гарах сөрөг нөлөө болон эерэг нөлөөллийг тооцоолсон иж бүрэн тооцоо судалгаа юм. Эдгээр сөрөг нөлөө, эерэг нөлөөллийг суурь мэдээлэл, бусад байгууллагын хийсэн ижил төстэй судалгаа, мэргэжилтнүүдийн санал дүгнэлтэд үндэслэн анх тооцоолсон. Эдгээр тооцоог болгоомжтой байдлаар гаргасан бөгөөд янз бүрийн таамаглал, төсөөллийг ил тод тусгасан. ЭАН үзүүлэх үйл ажиллагааны урьдчилсан тооцооны сүүлийн үеийн хувилбаруудад эдгээр сөрөг нөлөө, эерэг нөлөөг ОТ-н биологийн олон янз байдлын мониторинг, ОТ-н биологийн олон янз байдлын бусад судалгаанаас гарсан эмпирик мэдээлэлд үндэслэн тооцоолсон болно (ЭАН үзүүлэх үйл ажиллагааны таамаглалыг турших, сайжруулах ажил).

Биологийн олон янз байдлын мониторингийн мэдээлэлд жил тутам үнэлгээ хийж, ЭАН үзүүлэх үйл ажиллагааны тооцоололд ач холбогдолтой (дундаж болон итгэлцлийн интервал гэх мэт) эсэхийг нь үнэлнэ. Мониторингийн хүрээнд цуглуулсан мэдээлэлд илт мэдэгдэхүйц, ихээхэн

<b>Биологийн олон янз байдлын мониторинг, үнэлгээний төлөвлөгөө</b>		
Хүчинтэй болох: 2015.12.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е14-PLN-0006-М	Хувилбар: 1.0

хамаарал болон ач холбогдол бүхий өөрчлөлт (тухайлбал эн тэргүүнд хамгаалах шаардлагатай төрөл зүйлсийн тоо толгой ихээхэн буурсан бөгөөд энэ нь жам ёсны хувирал өөрчлөлтөөс гадуур байх магадлалтай бөгөөд ан агнуурын дарамт нэмэгдсэн гэх мэтийн төслийн дам нөлөөллөөс үүссэн байж болзошгүй байвал) орсон тохиолдолд ЭАН үзүүлэх үйл ажиллагааны урьдчилсан тооцоог жил бүр шинэчилнэ. ЭАН үзүүлэх үйл ажиллагааны урьдчилсан тооцоог өмнөх мэдээлэл, туршлага дээр үндэслэн таван жил тутам шинэчилж байна.

### 10. БАРИМТ БИЧГИЙН ХЯНАЛТ

Файлын нэр	ОТ-10-Е14-PLN-0006-Е-Биологийн олон янз байдлын мониторинг, үнэлгээний төлөвлөгөө
Тодорхойлолт	Биологийн олон янз байдлын мониторинг, үнэлгээний төлөвлөгөө
Эх зохиогч	Даян Дэлхийн Биологийн Олон Янз Байдлыг Хамгаалах Байгууллага
Боловсруулсан огноо	2015.12.01
Баталсан	Дэннис Хосак
Баталсан огноо	2016.03.01
Өөрчлөлтийн бүртгэлийн дугаар	##

Эрсдлийн зэрэглэл	Үнэлгээ хийсэн огноо	Эрсдэл үнэлэгч	Хянах хуваарь	Дараагийн хянах огноо
Дунд	2016.03.01	Дэннис Хосак	Хоёр жил тутамд	2018.03.01

Хувилбар	Хянан засварласан огноо	Зохиогч	Баталсан	Хянан засварлалтын тэмдэглэгээ
1.0	2016.03.01	Хэд хэдэн	Дэннис Хосак	Батлав.